



**“МОН БИЙФ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны ¹⁰ сарын ²³ өдөр

Дугаар 1.

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсгийг удирдлага болгон, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.31, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхын саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн анхдугаар хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Жанцанхорлоогийн Барсболдыг сонгосныг баталсугай.

2.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь компанийн эрх, ашгийг дээдлэх зарчмыг баримтлан Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон ТУЗ-ийн хурлаар баталсан дүрэм, журмийн дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  ЖАНЦАНХОРЛООГИЙН БАРСБОЛД



**“МОН БИЙФ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны ¹⁰ сарын ²³ өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот


Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7_55-д тус тус заасныг удирдлага болгон, ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхын саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ж.Барсболдоос ТУЗ-ын нарийн бичгийн даргад томилуулахаар санал болгосон Мөнхбаяр овогтой Номинчулууг хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар сонгосныг баталсугай.

2.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь компанийн эрх, ашгийг дээдлэх зарчмыг баримтлан компанийн дүрэм болон ТУЗ-ийн хурлаар баталсан дүрэм, журмийн дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Ж.БАРСБОЛД

МОН БИЙФ ХК-ИЙН ТУЗ-ЫН
2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ
ӨДРИЙН .. ДУГААРТАЙ ТОГТООЛЫН
ХАВСРАЛТ 1.

**МОН БИЙФ ХК-ИЙН ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
МӨРДӨГДӨХ ЖУРАМ**

№	Журам	Дугаар
1	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЖУРАМ	ХАВСРАЛТ 2
2	ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ	ХАВСРАЛТ 3
3	ТУЗ-ИЙН НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДҮРЭМ	ХАВСРАЛТ 4
4	ТУЗ-ИЙН ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ ДҮРЭМ	ХАВСРАЛТ 5
5	ТУЗ-ИЙН АУДИТЫН ХОРООНЫ ДҮРЭМ	ХАВСРАЛТ 6
6	ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ	ХАВСРАЛТ 7
7	МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ЖУРАМ	ХАВСРАЛТ 8
8	ЁС ЗҮЙН ДҮРЭМ	ХАВСРАЛТ 9
9	НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО	ХАВСРАЛТ 10
10	ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО	ХАВСРАЛТ 11
11	АШИГ СОНИРХЛЫН ЖУРАМ	ХАВСРАЛТ 12



**“МОН БИЙФ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны ¹⁰ сарын ²³ өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, холбогдох
бусад журмыг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дэх хэсгийг удирдлага болгон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дүрмийн төслийг хэлэлцсэний үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг болон холбогдох бусад журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг нийт гишүүдэд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  Ж.БАРСБОЛД



**“МОН БИЙФ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 7

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх
хороодыг байгуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дугаар зүйлийн 81.1, 81.2 дах хэсэг, компанийн дүрмийн 7 дугаар зүйлийг удирдлага болгон, ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхын саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороог байгуулсугай.
2. Дотоод аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодын бүрэлдэхүүнийг хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн 100 хувийн саналын дагуу энэхүү тогтоолын хавсралт №01-т заасан ёсоор байгуулахыг баталсугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь харьяалсан хороодын үйл ажиллагаанд зохих журмын дагуу оролцож компанийн эрх, ашгийг дээдлэх зарчмыг баримтлан аливаа сонирхлын зөрчлөөс ангид байж, компанийн нууцыг чанд хадгалж шударгаар ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  Ж.БАРСБОЛД

МОН БИЙФ ХК-ИЙН ТУЗ-ЫН
2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ
ӨДРИЙН 4 ДУГААРТАЙ ТОГТООЛЫН
ХАВСРАЛТ.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН**

№	Хороод	Гишүүний төрөл
Нэр дэвшүүлэх хороо		
1	Э.Пүрэвлхам	Дарга
2	Д.Байлийхүү	Гишүүн
3	Э.Төмөртогтох	Гишүүн
Цалин урамшууллын хороо		
1	О.Доржханд	Дарга
2	Д.Байлийхүү	Гишүүн
3	Э.Төмөртогтох	Гишүүн
Аудитын хороо		
1	Д.Наранцэцэг	Дарга
2	Д.Байлийхүү	Гишүүн
3	Ц.Оюунцэцэг	Гишүүн



**“МОН БИЙФ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 5

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлыг үүрэгт ажлаас чөлөөлж,
Гүйцэтгэх захирлыг шинээр томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дэх хэсгийг удирдлага болгон Намхайдорж овогтой Ариунбаатарын гаргасан хүсэлт, ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхын саналыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тус компанийн Гүйцэтгэх захирал Намхайдорж овогтой Ариунбаатар нь Гүйцэтгэх захирлын ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасантай холбогдуулан 2022 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Сүрэндулам овогтой Сайнбилэгтийг 2022 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн Гүйцэтгэх захирлаар томилсугай.

3. Сүрэндулам овогтой Сайнбилэгт нь гүйцэтгэх захирлаар томилогдсон өдрөөс хойш компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, компанийн харилцагч банканд дансны зарлагын хөдөлгөөн хийх, гүйлгээний баримтад гарын үсэг зурах, компанийн эрх ашигт нийцэх албан бичиг баримтад компанийг төлөөлөн баталгаажуулах эрхтэй болохыг дурдсугай.

4. Ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан хариуцан ажиллаж байсан ажил үүргийг шинээр томилогдсон Гүйцэтгэх захирал С.Сайнбилэгтэд хүлээлгэн өгөхийг Н.Ариунбаатарт даалгасугай.

5. Н.Ариунбаатартай холбогдох тооцоог хийх, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилт хийхийг Санхүүгийн Албанд даалгасугай.

6. Энэхүү тогтоолд заасан холбогдох өөрчлөлтүүдийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн Этгээдийн Бүртгэлийн Газарт бүртгүүлэх, шаардлагатай материалыг бүрдүүлэн өгөх, хүлээн авах, тэдгээрт гарын үсэг зурах эрхийг тус компанийн хуулийн зөвлөх Мөнхбаяр овогтой Номинчулуу /РД: КЮ95081405/-нд итгэмжилсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Ж.БАРСБОЛД



**“МОН БИЙФ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны ¹⁰ сарын ²³ өдөр




Дугаар 6

Улаанбаатар хот

Их хэмжээний болон сонирхлын
зөрчилтэй хэлцэл хийх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16, 76.1.17, 87 дугаар зүйл, 89 дүгээр зүйл, 92 дугаар зүйлийн 92.1, 92.5, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.33.16, 7.33.17д заасныг тус тус удирдлага болгон, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Мон Бийф” ХК-ийн бизнес төлөвлөгөө хэрэгжүүлэх, улмаар ашигт ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор “Хаан Банк” ХХК, “Таван Богд Трейд” ХХК болон түүний хамаарал бүхий, охин компаниудтай тус тус байгуулахаар төлөвлөж буй их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг Гүйцэтгэх захирал /С.Сайнбилэгт/-д зөвшөөрсүгэй.
2. Дээрх сонирхлын зөрчилтэй буюу холбоотой талуудтай хийгдэх хэлцэл дээр хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /С.Сайнбилэгт/-д үүрэг болгосугай.
3. Жилийн эцэст энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан талуудтай хийгдсэн гэрээний гүйцэтгэлийг гарган Төлөөлөн Удирдах зөвлөлд танилцуулахыг Ерөнхий нягтлан бодогч /Б.Ганболор/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  Ж.БАРСБОЛД
ХАРААТ БУС ГИШҮҮН  Д.БАЙЛИЙХҮҮ
 Д.НАРАНЦЭЦЭГ